



**“УЛААНБААТАР ТӨМӨР ЗАМ” ХНН-ИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД 2025 ОНЫ
ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН БАЙДЛААР ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ,
ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН АЖЛЫН ТОВЧ ТАЙЛАН**

2025.07.30

Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлын зорилго

“Улаанбаатар төмөр зам” /УБТЗ/ хувь нийлүүлсэн нийгэмлэг /ХНН/-ийн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийж, үнэлэлт, дүгнэлт өгөх, цаашид анхаарч ажиллах асуудлын талаар санал, зөвлөмж боловсруулах замаар яамны удирдлага, албан тушаалтныг холбогдох мэдээллээр хангах зорилгоор энэхүү хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлыг гүйцэтгэлээ.

Төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээнүүдийн хэрэгжилтийг дүгнэхдээ Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолоор баталсан “Хяналт-шинжилгээ хийх журам”, “Үнэлгээ хийх журам”, “Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэх журам”, Зам, тээврийн хөгжлийн сайдын 2021 оны А/87 дугаар тушаалаар баталсан “Зам, тээврийн хөгжлийн яам болон харьяа байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам”-ыг үндэслэл болгосон.

Хоёр. Танилцуулга

“УБТЗ” ХНН-ийн 2025 оны эхний хагас жилийн үйл ажиллагааг Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт, Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлт, Сайдын тушаалын биелэлт, ТНБД-ын тушаалын биелэлт, Шилэн дансны хөтлөлтийн үнэлгээ, Ил тод байдлын үнэлгээ гэсэн 6 үзүүлэлтээр дүгнэсэн бөгөөд нэгдсэн дүнгээр 90.8%-тай байна.

2.1. “УБТЗ” ХНН-ийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан ажил, үйлчилгээний хэрэгжилтийн байдлыг доорх хүснэгтэд үзүүлэв.

Нийт заалт	Үүнээс						Хугацаа болоогүй	Биелэлтийн хувь
	100%	90%	70%	50%	30%	0%		
52	36	-	-	1	4	1	10	89.8

2.2. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн явцыг дүгнэвэл:

Нийт заалт	Үүнээс				Биелэлтийн хувь
	Хэрэгжсэн	Хэрэгжээгүй	Хугацаа болоогүй	Хүчингүй болсон	
15	15	-	-	-	100.0

2.3. Сайдын тушаалаар өгсөн үүрэг даалгаврын биелэлт:

Нийт заалт	Үүнээс				Биелэлтийн хувь
	Хэрэгжсэн	Хэрэгжээгүй	Хугацаа болоогүй	Хүчингүй болсон	

**ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ**

24	17	7	-	-	70.8
----	----	---	---	---	------

2.4. ТНБД-ын тушаалаар өгсөн үүрэг даалгаврын биелэлт:

Нийт заалт	Үүнээс				Биелэлтийн хувь
	Хэрэгжсэн	Хэрэгжээгүй	Хугацаа болоогүй	Хүчингүй болсон	
6	6	-	-	-	100.0

2.5. Шилэн дансны хөтлөлтийн үнэлгээ:

Мэдээлэл	Нийт заалт	Үүнээс					Биелэлтийн хувь
		100%	70%	30%	0%	Хугацаа болоогүй	
хөрөнгө оруулалт, тендер, худалдан авалт	4	2	-	-	-	2	100.0
бусад	3	1	-	-	-	2	100.0
Нийт	7	3	-	-	-	4	100.0

2.6. Ил тод, нээлттэй байдлын шалгуур үзүүлэлтүүдийн үнэлгээ:

Нийт заалт	Үүнээс						Биелэлтийн хувь
	100%	70%	50	30%	0%	хамааралгүй	
46	19	1	1	3	1	21	84.4

Гурав. Үнэлэлт, дүгнэлт**Төлөвлөлтийн байдал:**

“УБТЗ” ХНН 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулахдаа Хяналт-шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газраас өгсөн зөвлөмжийн дагуу арга хэмжээний зорилтот түвшнийг улирал бүрээр төлөвлөөгүй байна. /2.2, 2.12, 2.14, 2.20, 3.3, 6.3, 7.8, 8.2, 8.3/

Хэрэгжилтийн байдал:

1) “УБТЗ” ХНН-ийн 2025 оны эхний хагас жилийн үйл ажиллагааг Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт, Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлт, Сайдын тушаалын биелэлт, ТНБД-ын тушаалын биелэлт, Шилэн дансны хөтлөлтийн үнэлгээ, Ил тод байдлын үнэлгээ гэсэн 6 үзүүлэлтээр дүгнэсэн бөгөөд нэгдсэн дүнгээр 90.8%-тай үнэлэгдсэн байна.

2) 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд Оорцог-Энгэр зөрлөгийн зам сумын өргөтгөлийн ажлыг эхлүүлэхээр төлөвлөсөн боловч, уг ажлыг “Багахангай өртөөг өргөтгөх ажлыг зохион байгуулах тухай” А-453 дугаар тушаалаар шилжүүлсэний улмаас хэрэгжээгүй байна.



3) Улаанбаатар цэрэгжүүлсэн хамгаалах ангид орчин үеийн иж бүрэн тоноглол бүхий зориулалтын галын үндсэн авто машин худалдан авахаар зарласан тендер амжилтгүй болсноос үүдэн гэрээ байгуулах боломжгүй болсон тул уг ажил төлөвлөсөн хугацаанд хэрэгжээгүй бөгөөд хэрэгжилт хангалтгүй дүгнэгдэж байна.

4) Авлигыг үл тэвчих хандлагыг бий болгох болон цахим гэмт хэргээс урьдчилан сэргийлэх сургалт зохион байгуулах, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, хүүхдийн эрхийг хамгаалах чиглэлээр үе шаттайгаар сургалт зохион байгуулах хоёр арга хэмжээний хүрээнд мэргэжлийн байгууллагатай хамтран сургалтын төлөвлөгөө боловсруулж, батлуулахаар төлөвлөсөн. Гэтэл Тээврийн цагдаагийн албаны Төмөр замын цагдаагийн газартай хамтран дотоод төлөвлөгөө баталсан нь тухайн арга хэмжээний зорилтот түвшинтэй нийцээгүй байх тул уг арга хэмжээний гүйцэтгэл зөрүүтэй тайлагнагдаж байна.

5) “УБТЗ” ХНН-д тогтвор суурьшилтай ажилласны төлөө ажилтнуудыг шагнаж, урамшуулах ажлыг зохион байгуулах ажлын хүрээнд хэрэгжүүлсэн арга хэмжээ нь судалгааны үндэслэл сул, төлөвлөлт хангалтгүй байснаас шалтгаалан зорилтот түвшинд хүргэж ажиллаагүй байна.

6) Зам, тээврийн сайдын тушаалаар өгсөн үүрэг даалгаврын хүрээнд төмөр замын тээвэр зохион байгуулалтыг тэнцвэртэй байлгах чиглэлээр тодорхой уулзалт, хэлэлцээ хийсэн боловч дамжин өнгөрөх чингэлгийн урсгалыг тэнцвэржүүлэх, хуримтлал үүсэхээс сэргийлэх бодит үр дүн хангалтгүй хэвээр байна. Мөн Замын-Үүд-Эрээн боомтоор хоосон чингэлэгийг буцаахдаа хаягжуулалтыг солихгүй байх баталгааг Хятадын талаас албан ёсоор санал ирүүлээгүй. Түүнчлэн Замын-Үүд дэх төмөр замын боомтыг хөгжүүлэх төлөвлөгөөнд тусгагдсан бүтээн байгуулалтын ажлууд болон Замын-Үүд-Эрээн хилийн зөрлөг дээр хилийн хяналт, шалгалтыг хөнгөвчлөх зориулалтын хяналтын камерыг суурилуулах ажил нь санхүүжилтийн эх үүсвэр бүрэн шийдэгдээгүйн улмаас хэрэгжээгүй байна.

7) Сайдын тушаалаар өгсөн даалгаврын хүрээнд аюултай ачааг хатуу зурмагаар тээвэрлэх зохицуулалтыг хэрэгжүүлэх боломжийг судалж эхэлсэн боловч тээвэрлэлтийн урсгал, гаалийн хяналттай холбоотой зарим асуудал тодорхойгүй байгаагаас шалтгаалан хэрэгжилт хангагдаагүй, цаашид нарийвчилсан зохицуулалтын талаар хэлэлцэх шаардлагатай байна. Мөн нефть, нефтийн бүтээгдэхүүний тээврийн суурь бүтцийн тарифыг 50 хүртэл хувиар бууруулах нь “УБТЗ” ХНН-д их хэмжээний алдагдал үүсгэх эрсдэлтэй, түүнчлэн Ерөнхий хороогоор хэлэлцүүлэн шийдвэр гаргуулах үйл ажиллагааг зохион байгуулаагүйгээс тарифт өөрчлөлт ороогүй байна.

8) “УБТЗ” ХНН-ийн 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд туссан 52 арга хэмжээний хэрэгжилт 89.8% байна. Үүнээс 85.7% нь хүрэх түвшиндээ бүрэн хүрсэн болон хүрэх шатандаа, 14.2% нь төлөвлөсөн үр дүндээ бүрэн хүрээгүй байна.

9) Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг зорилтуудаар нь авч үзвэл:

Зорилт	Арга хэмжээ	Хэрэгжилтийн хувь
--------	-------------	-------------------

**ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ**

Зорилт 1. УБТЗ-ын тээврийн хэмжээг нэмэгдүүлнэ.	7	100.0
Зорилт 2. Төмөр замын дэд бүтцийн нэвтрүүлэх чадвар, хөдлөх бүрэлдэхүүний засварын баазын хүчин чадлыг сайжруулна.	20	90.0
Зорилт 3. Компаний засаглалыг сайжруулж удирдлагын тогтолцоог боловсронгуй болгоно.	4	100.0
Зорилт 4. Хөдөлмөрийн аюулгүй байдлын эрх зүйн орчныг боловсронгуй болгож хяналтыг сайжруулна.	3	100.0
Зорилт 5. Цахим шилжилтийг эрчимжүүлж мэдээллийн технологийг хөгжүүлнэ.	3	100.0
Зорилт 6. Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлж хуулийн хэрэгжилтийг хангуулна.	3	30.0
Зорилт 7. Хүний нөөц, нийгмийн салбарын бодлого зохицуулалтын хэрэгжилтийг хангана.	8	91.7
Зорилт 8. Салбарын эрх зүйн орчинг бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.	4	65.0

10) Тус нийгэмлэгийн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, өгсөн зөвлөмжүүдээс дараах зөвлөмжүүд хэрэгжээгүй, удаашралтай байна. Үүнд:

1. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрээр өгсөн үүрэг даалгаврыг хэрэгжилтийг тайлагнахдаа дэвшүүлсэн зорилтын хүрээнд зохион байгуулсан гол ажлаа хүрсэн үр дүн, зорилтот түвшинтэй нь харьцуулж, хэрэгжилтийг сайжруулах зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллах;

2. Тээврийн эрх зүйн орчныг боловсронгуй болгох, ачаа, зорчигч тээврийн хэмжээг нэмэгдүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааг сайжруулах ажлыг эрчимжүүлэх;

3. Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд туссан хөрөнгө, санхүүжилт шаардагдахгүйгээр хэрэгжүүлэх сургалт зохион байгуулах ажлыг эрчимжүүлэн төлөвлөсөн ажлаа цаг тухайд нь гүйцэтгэж, зорилтот түвшинд хүргэх, (6.2, 6.3);

4. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилтийг ханган, төрийн үйл ажиллагааг нээлттэй, хүртээмжтэй, хүнд сурталгүй, авлигаас ангид байлган, нийгэмлэгийн үйл ажиллагааны талаарх мэдээллийг тогтмол шинэчлэн, бүрэн байршуулж, хэрэгжилтийг хангах;

Дөрөв. Санал, зөвлөмж

1. Жилийн хугацаанд хэрэгжүүлэх гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж, батлуулахдаа арга хэмжээгээ оновчтой тодорхойлон, хэрэгцээ шаардлагад нийцсэн, судалгаанд тулгуурласан арга хэмжээ төлөвлөж, цаашид ижил төрлийн алдаа гаргахгүй байх; /Оорцог-Энгэр зөрлөгийн зам сумын өргөтгөлийн ажлыг эхлүүлэх/

2. Орчин үеийн иж бүрэн тоноглол бүхий зориулалтын галын үндсэн авто машин худалдан авах тендерийг дахин зарлаж, гэрээ байгуулах ажлыг яаралтай зохион байгуулах;

3. Мэргэжлийн байгууллагатай хамтран авлигыг үл тэвчих хандлагыг бий болгох болон цахим гэмт хэргээс урьдчилан сэргийлэх сургалт зохион байгуулах, гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, хүүхдийн эрхийг хамгаалах чиглэлээр үе шаттайгаар сургалт зохион байгуулах сургалтын төлөвлөгөөг боловсруулан батлуулж, хэрэгжилтийг хангах;



ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ

4. “УБТЗ” ХНН-д тогтвор суурьшилтай ажилласан ажилтнуудыг шагнаж, урамшуулах ажлыг зорилтот түвшинд хүргэж ажиллах;

5. Зам, тээврийн сайдын тушаалаар өгсөн үүрэг даалгаврыг бүрэн хэрэгжүүлж ажиллахад анхаарч, хэрэгжилтийг сайжруулах чиглэлээр зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллах;

6. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилтийг ханган, төрийн үйл ажиллагааг нээлттэй, хүртээмжтэй, хүнд сурталгүй, авлигаас ангид байлган, нийгэмлэгийн үйл ажиллагааны талаарх мэдээллийг тогтмол шинэчлэн, бүрэн байршуулах;

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ГАЗАР